



БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

**БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМАН ДАХЬ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛСАН
2025 ОНЫ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭ**

2025 он

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭ (2025 он)

1. Гэрээ байгуулагч Талууд:

1.1 Нэг талаас: Төсвийн төвлөрүүлэн захирагч

Боловсролын ерөнхий газрын дарга

Төмөр-Очир НЯМ-ОЧИР

1.2 Нөгөө талаас: Төсвийн шууд захирагч

Хэнтий аймгийн Бор-Өндөр суман дахь

Мэргэжлийн боловсролын сургуулийн захирал

О.ГИБРАТ

нар дор дурдсан асуудлаар харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

2. Гэрээний агуулга, зорилго

2.1 “Байгууллагын үйл ажиллагааны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө” нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд төсвийн төвлөрүүлэн захирагчаас хэрэгжүүлэх хөтөлбөр, нийт болон тусгай арга хэмжээнүүд, манлайллын зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-үүд болон бусад эрх үүргийг тусгав.

2. Энэхүү гэрээний зорилго нь үйл ажиллагааг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсвийн болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зэрэг манлайллын зорилтуудыг хангах талаар төсвийн шууд захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино.

НЭГ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

1. Төсвийн шууд захирагчийн хүлээх үүрэг

1.1. Энэхүү гэрээний хавсралт болох “Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан **50 нийт арга хэмжээг** гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлнэ.

1.2. Энэхүү гэрээний хавсралт болох “Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээнээс төсвийн төвлөрүүлэн захирагчийн тусгайлан сонгосон **6 тусгай арга хэмжээг** гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлнэ.

1.3. Төрийн албаны удирдах ажилтны манлайллын зорилтын хүрээнд дор хэрэгжүүлнэ.

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧТАЙ БАЙГУУЛЛАГЫН ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧИЙН ХИЙХ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТ**

Манлайллын зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа)
1	2	3
1. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар: Зорилт-1: Төрийн албан хаагчийн шударга ёс, хуулийг дээдлэх, тэгш байдлыг хангах, хариуцлага хүлээх, олон нийтэд үйлчлэх ёс зүйн хэм хэмжээг баримталж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	а) Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. б) Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн байгууллагын соёл, дэг журмыг төлөвшүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	Тоо хэмжээ: Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангаж 3 арга хэмжээ зохион байгуулсан байна. Чанар: Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй байлгаж хүнд сурталгүй төрийн үйлчилгээг иргэдэд хүргэнэ. Хугацаа: 2025 он
2. Байгууллагын ил тод байдлыг хангах талаар: Зорилт-1: Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах Зорилт-2: Төсвийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалтын ил тод байдлыг ханган ажиллах. Зорилт-3: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах.	а) Байгууллагын үйл ажиллагаа, төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналыг тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлнэ. б) Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын дагуу хуваарилагдсан санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зарцуулна. в) Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн дагуу тендер зарлаж, ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллана.	Тоо хэмжээ: Шилэн дансны мэдээг 20 төрлөөр хуулийн хугацаанд 100% оруулсан байна. Чанар: Байгууллагын үйл ажиллагаа нээлттэй ил тод болсон байна. Хугацаа: 2025 он

3. Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар: Зорилт-1: Байгууллагын үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах.	а) Эд хөрөнгийн тооллого, тооцоо, бүртгэлийг үнэн зөв, чанартай гүйцэтгэж, ашиглалтыг сайжруулна.	Тоо хэмжээ: Хагас, бүтэн жилээр Чанар: Байгууллагын хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжирсан байна. Хугацаа: 2025 он
4. Байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, мэдээллээр хангах талаар: Зорилт-1: Байгууллагын ажилтнуудын хандлага, мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах. Зорилт-2: Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй байдлыг ханган зохион байгуулах Зорилт-3: Төрийн захиргааны байгууллагаас өгсөн мэдээ, мэдээллийг багш, ажилтнуудад цаг тухайд нь мэдээлж, шаардлагатай тохиолдолд хамт олны хурлаар шийдвэрлэх	а) Багш, албан хаагчдын хандлага, мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажлын байранд хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ. б) Төрийн захиргааны байгууллагаас зохион байгуулах багш, хүний нөөцийг хөгжүүлэх сургалт, үйл ажиллагаанд бүрэн хамруулна.	Чанар: 2025 оныг “Найрсаг харилцаа, эерэг хандлага” зорилтот жил болгон зарлаж багш ажилтнуудын хандлага, мэдлэг чадварыг дээшлүүлэх ажлыг төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна. Төлөвлөгөөт сургалтууд болон ажлын байранд зохион байгуулагдах сургалтад багш, албан хаагчдыг хамруулж хөгжлийг дэмжиж ажилласан байна. Хугацаа: 2025 он
	а) Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулна. б) Хүний нөөцийн мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлэн ажиллана. в) Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, багш, ажилтнуудыг мэдээ, мэдээллээр шуурхай хангаж, шаардлагатай тохиолдолд хамт олны хурлаар шийдвэрлэж, үр дүнг тооцно.	Чанар: Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохин байгуулж бүтэц орон тооны хангалтыг 100% хангасан байна. Хүний нөөцийн мэдээллийн санд үндсэн болон түр тушаалтай албан хаагчдын мэдээллийг тухай бүр үнэн зөв оруулсан байна. Мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангаж хамт олны хурлыг сар бүр хийж төлөвлөгөө, тайлан мэдээллийг хүргэж ажилласан байна. Хугацаа: 2025 он
5. Жендэрийн тэгш байдлыг хангах талаар: Зорилт-1: Жендэрийн тухай	а) Багш, ажилчид, суралцагчдад жендэрийн тухай хууль тогтоомжийг танилцуулж, жендэрийн тухай	Тоо хэмжээ: 2 удаа сургалт, арга хэмжээ зохион байгуулсан байна.

хууль тогтоомжийг сурталчлан таниулах. Зорилт-2: Жендэрийн тэгш байдлыг хангасан тэнцвэрт орчин бүрдүүлэх.	ойлголт хэлэлцүүлэг, сургалт, арга хэмжээг зохион байгуулна. б) Байгууллагын үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлыг хангаж ажиллана. в) Жендэрийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж тухайн асуудлыг хариуцсан албан тушаалтныг тодорхойлж хариуцуулна.	Чанар: Жендэрийн тэгш байдлыг хангаж жендэрийн мэдрэмжтэй тайлан төлөвлөгөөг боловсруулж хэвшсэн байна. Хугацаа: 2025 он
6. Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга батыг сахин ажиллах. Зорилт-1: Төсвийн тухай хууль, бусад хуулийг чанд мөрдөн ажиллах. Зорилт-2: Батлагдсан төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй ажиллах	а) Байгууллагын 2025 онд холбогдох тайлан, мэдээг цаг хугацаанд нь гаргаж тайлагнана. б) 2025 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн цаг хугацаанд нэгтгүүлж, батлуулна.	Тоо хэмжээ: 2,377,520,0 Чанар: Хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, зарцуулалтыг ил тод байдлыг хангаж, тайлан мэдээ болон төсвийн төсөөллийг үнэн бодитой гаргасан байна. Хугацаа: 2025 он

1.4. Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ.
(Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 2.6 дахь заалт)

Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт (шалгуур үзүүлэлт)	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам (өөрийгөө хөгжүүлэх чиглэл)	Хуанлийн хугацаа, хүн/өдөр
1	2	3
Мэдлэг чадвараа дээшлүүлэх Зорилт-1:	Зөвлөх багшийн шалгуур шаардлагын дагуу мэргэжлийн зэргээ ахиулсан байна.	2025.06
Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт-2:	Үндэсний бичгийн мэдлэгээ дээшлүүлэн дунд шатны мэдлэгтэй болсон байна.	2025.11
Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт-3:	Санхүү нягтлан бодох бүртгэлийн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна.	2025.11

1.5. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж болон холбогдох эрхзүйн акт, гэрээ хэлэлцээр, стандартыг мөрдөж ажиллана.

1.6. Сургалтын байгууллагын нийт багш ажилтан, суралцагчийн зүгээс байгууллагын орчинд аливаа жагсаал, цуглаан зохион байгуулах, гэмт хэрэг үйлдэх,

сургуулийн хэвийн үйл ажиллагаанд харшилсан аливаа үйлдэл гаргуулахгүй байхад арга хэмжээ авч ажиллана.

1.7. Сургалтын байгууллагын суралцагчийг аялал зугаалга зохион байгуулах, архи согтууруулах ундаа, хорт зуршил, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллээс ангид байлгах, түүний улмаас үүсэх хор уршиг, сөрөг үр дагавар бий болохоос сэргийлэх тодорхой төлөвлөгөөтэйгөөр ухуулан таниулах, сурталчлах, нөлөөллийн арга хэмжээ авах, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах санал, санаачилга бий болгоно.

1.8. Сургалтын байгууллагын багш, албан хаагчдад авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилж, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах, авлигатай тэмцэх санаачилга өрнүүлнэ.

1.9. Сургалтын байгууллагын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, хяналт тавих, ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.10. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгчийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлдэг хөтөлбөр арга хэмжээний хүрээнд “Санхүүгийн дэмжлэг, Бичил зээл зэрэг”-ээс санхүүжилтийн дэмжлэг авч цаашдын гарааны бизнесээ эхлүүлэхэд нь удирдлагын зүгээс мэргэжил арга зүйгээр болон төсөл бичихэд нь дэмжлэг үзүүлж оролцуулна.

2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүлээх үүрэг

2.1. Төсвийн шууд захирагчтай байгуулах гэрээнд тусгаж хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ (нийт болон тусгай арга хэмжээ)-үүд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

2.2. Манлайллын зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

2.3. Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллага хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай төсвийг эрх бүхий байгууллагаар батлуулна.

2.4. Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хугацаанд нь хийнэ.

2.5. Гэрээнд тусгагдсан хөтөлбөр, нийт болон тусгай арга хэмжээнүүд, манлайллын зорилтоо хэрэгжүүлэхэд нь төсвийн шууд захирагчид байнгын дэмжлэг тусалцаа үзүүлж, гэрээний биелэлтийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6. Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

ХОЁР. БУСАД ЗҮЙЛ

3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

3.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэж, албажуулан гэрээнд хавсаргана. Энэхүү гэрээний хугацаа сунгагдахгүй.

4. Гэрээ байгуулах болон дүгнэх хугацаа:

4.1. Гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаагаар байгуулна.

4.2. Төсвийн шууд захирагч гэрээний биелэлтийг 12 дугаар сарын 05-ны дотор багтаан тайлагнаж, төсвийн төвлөрүүлэн захирагч 12 дугаар сарын 15-ны дотор багтаан түүний биелэлтийг дүгнэнэ.

5. Гэрээний урамшуулал ба хариуцлага

5.1. Төсвийн шууд захирагч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн тохиолдолд түүнийг урамшуулах асуудлыг төсвийн төвлөрүүлэн захирагч холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актад заасны дагуу шийдвэрлэнэ.

5.2. Төсвийн шууд захирагч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төсвийн төвлөрүүлэн захирагч түүнд туслалцаа дэмжлэг үзүүлэх, шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6. Гэрээ байгуулсан:

Төсвийн төвлөрүүлэн захирагч	
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА	
	/Т.НЯМ-ОЧИР/
2025-01-15	
Төсвийн шууд захирагч:	
ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМАН	
ДАХЬ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН	
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ	
	/ О.ГИБРАТ /
2025-01-15	

ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМАН ДАХЬ
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн төвлөрүүлэн захирагч

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Т.НЯМ-ОЧИР/

Тэмдэг

2025 оны 01 дүгээр сарын 15 өдөр

Төлөвлөгөө баталсан:

Төсвийн шууд захирагч

ЗАХИРАЛ
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/О.ГИБРАТ/

Тэмдэг

2025 оны 01 дүгээр сарын 15 өдөр

БОР-ӨНДӨР МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв / мянга/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрэх түвшний биелэлт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 1.1. Сургалтын байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, байгууллагын менежментийг сайжруулах							
1.1.1	Сургалтын байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана.	Улсын төсөв	Стратеги төлөвлөгөөний биелэлтийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хувь	Хувь: 90%	95%	2025 оны эхний хагас жилд стратеги төлөвлөгөөнд нийт 21 ажил төлөвлөгөөнд тусгагдсанаас нийт 20 ажил бүрэн хийгдсэн байна.	95%
1.1.2	Сургалтын байгууллагын менежментийг сайжруулна.	Улсын төсөв	Судалгаа инновац, төслийн баг, Хүүхэд хамгаалал, хандлага төлөвшлийн баг, Элсэлт сурталчилгааны багийг тус тус байгуулан төлөвлөгөөний дагуу ажиллана	Хувь: 0%	80%	Захирлын 2025 оны 02 сарын 14-ны өдрийн А/19 тоот тушаалаар 3 ажлын хэсгийг байгуулсан. Үүнд: Судалгаа инновац, төслийн баг- 5 ажил арга хэмжээ, Хүүхэд хамгаалал, хандлага төлөвшлийн баг-7 ажил арга хэмжээ, Элсэлт сурталчилгааны баг-8 ажил арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.	80%
1.1.3	Байгууллагын бүтэц орон тоо, хүний нөөцийн	Улсын төсөв	Нийт багш, ажилтны хүйсийн харьцаа нийт	44, эр-10, эм-34	90%	Боловсролын яамнаас жишиг бүтэц орон тоо батлагдаагүй байгаа	90%

	бүрдүүлэлтийг сайжруулна.		Нийт багш, ажилтанд ногдох мэргэжлийн багш хувь (хүйсээр ангилсан) Нийт багш, ажилтанд ногдох ерөнхий эрдмийн багш хувь (хүйсээр ангилсан) Нийт багш, ажилтанд ногдох удирдлага болон захиргааны ажилтан хувь (хүйсээр ангилсан) Нэг багшид ногдох суралцагчийн тоо	18% (эр-3, эм-5) 18% (эр-0, эм-8) 0,9%, (эр-1, эм-3) Тоо - 21		боловч 2025 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар сургуулийн бүтэц орон тоог шинэ жишгийн дагуу хэлэлцүүлсэн. 2024-2025 оны хичээлийн жилд Монгол хэл уран зохиолын багш-1, Мэдээллийн технологийн багш-1, Цахилгааны мэргэжлийн багш-1, биеийн тамирын багш-1, Математикийн цагийн багш-1, Авто механикийн мэргэжлийн багш-1, Жолооч-1 Сантехникч-1, тус тус шинээр ажилд авч хүний нөөцийн бүрдүүлэлтийг хангаж ажиллаж байна.	
1.1.4	Эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн хөтөлбөрийг шаттайгаар магадлан итгэмжлүүлнэ. үе	Улсын төсөв: 12000.0	Магадлан итгэмжлэлийн сургалт зөвлөмж-2, Гагнуурын мэргэжлийн хөтөлбөрөөр магадлан итгэмжлэлд орно -1 хөтөлбөр	0%	100%	БМИҮЗ-с 2 удаагийн тайлан боловсруулах зөвлөмжийн цахим сургалтыг авсан. Мөн 20/2024 тоот гэрээний дагуу шинжээчийн баг томилогдон ажиллаж байна.	90%
1.1.5	Сургалтын үйл ажиллагааны чанарыг	Улсын төсөв: 100.0	Чанарын баталгаажилтуулалтын багийн үйл ажиллагааг сайжруулж,	20%	100%	Мэргэжлийн боловсролын сургуулийн Дотоод чанарын баталгаажилтын	90%

	сайжруулахад чанарын баталгаажуулалтын багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх		төлөвлөгөө, хэрэгжилтийг хангаж ажиллана. Хөндлөнгийн үнэлгээ- 1, Сэтгэл ханамжийн судалгаа-2			багийг 2025 оны 02 дугаар сарын 19-ны Захирлын А/16 тоот тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчилсэн. Багийн гишүүд 2025.03.24,25-ны өдрүүдэд Говьсүмбэр ПТК, Төв аймаг ПТК, Техник технологийн ПТК, Үйлдвэр урлалын ПТК тус сургуулиудаар баг бүрэлдэхүүн туршлага судалсан. Дотоод чанарын багийн төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу хичээлийн байр, дадлагын газар, дотуур байранд орчны үнэлгээ хийж дүгнэлт гаргасан. Мөн нийт багш ажилчдаас 2 удаа 1,2-р курсийн суралцагчдаас 2 удаа, дотуур байрны суралцагчдаас 3 удаа, багш нараас 1 удаа нийт-8 удаагийн давтамжаар сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг захирлын зөвлөлийн хуралд танилцуулсан. Нийт 4 зөвлөмжийг багш ажилтанд өгсөн.	
1.1.6	Бодлогын баримт бичиг, дүрэм журмыг холбогдох хууль,	Улсын төсөв:	Хөдөлмөрийн дотоод журам 1, хөдөлмөрийн гэрээ 1, хамтын гэрээ 1, хүний нөөцийн	80%	100%	- Бор-Өндөр МБС-ийн Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн	90%

	дүрэмд нийцүүлэн сайжруулж, шинэчлэх		хөгжлийн хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжтой уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулсан байна.			гэрээг шинэчлэн боловсруулж хамт олны хурлаар танилцуулж 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Захирлын А/10 тоот тушаалаар баталсан. - 2025 оны 03 сарын 11-ны өдөр “Хамтын гэрээг” хамт олны хурлаар хэлэлцэн шинэчлэн байгуулж Бор-Өндөр сумын ЗДТГ-т бүртгүүлсэн.	
Зорилт 1.2. Иргэний мэргэжил, ур чадвар эзэмших хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн чанартай боловсрол, сургалтын үйлчилгээ үзүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, тэгш хамруулах тухайн орон нутаг, бүс нутгийн бүх насны иргэд, нийгмийн салбар бүрийг хамарсан насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцоог бэхжүүлэх							
1.2.1	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд үндэслэн 2025-2026 оны хичээлийн жилийн элсэлтийн хяналтын тоог батлуулж, элсэлт зохион байгуулах.	Улсын төсөв: 10000.0	Иргэний мэргэжил, ур чадвар эзэмших хэрэгцээний судалгаа, үр дүн Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, үр дүн Элсэлт, төгсөлтийн харьцаа, тэтгэлэг авсан төгсөгчийн хувь, тоо Бодит элсэлт ба хүчин чадлын харьцаа (суралцагчийн тоо суудлын тооны харьцаа)	213:163, 76% 450:335, 74%	90%	2024-2025 оны хичээлийн жилийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг бүс, орон нутгийн хэмжээнд хийж 2025-2026 оны хичээлийн жилийн 11 мэргэжлээр 250 суралцагч элсүүлэх саналаа тоон болон чанарын судалгаанд үндэслэн боловсруулж сургуулийн Удирдах зөвлөлд танилцуулан Боловсролын яаманд хүргүүлсэн. Нэг ээлжинд 450 суралцагч хүлээн авах хүчин чадалтай анги танхимтай, 6 дадлагын газартай сургалтын үйл	90%

						ажиллагаагаа явуулж байна.	
1.2.2	Ажил олгогчтой хамтран төгсөгчдийг ажлын байртай болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	Улсын төсөв: 1000.0	Төгссөн суралцагчийн тоо Элсэгчийн тооны харьцаа Төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн хувь	213:163 76%, 64%	90% 70%	2025 оны 1 сард төгссөн 43 төгсөгчдийг ажлын байранд зуулгах өдөрлөгийг орон нутгийн ХХҮГ-н мэргэжилтэн болон Бор-Өндөр сумын УБҮ-ийн цех, хэсгийн дарга, хүний нөөцийн алба, Трансвест монголиа ХХК, Бласт тех ХХК-тай хамтран зохион байгуулсан. Өдөрлөгөөр 2025 оны төгсөгчдийн 27% нь ажлын байртай болсон.	90%
1.2.3	Суралцагчийн чадамжийн болон явцын үнэлгээний ахицыг үнэлж, сайжруулна.	Улсын төсөв: 10000.0	Суралцагчийн чадамжийн болон явцын үнэлгээний ахиц, үр дүн	73%	80%	3 жилийн сургалттай 5 мэргэжил 1 жилийн сургалттай 6 мэргэжил тус бүрээр чадамжийн нэгжийн үнэлгээг зохион байгуулсан. Чадамжийн нэгжээр анги тус бүрт үнэлгээг зохион байгуулж үр дүнг улирлаар тооцсон. Мэргэжлийн хичээлийн онолын үнэлгээ-83%, ур чадварын үнэлгээ 92.7% -тай тус тус үнэлэгдсэн. Өмнөх оныхоос дундаж гүйцэтгэл 7.8% өссөн үзүүлэлтэй байна.	90%
1.2.4	Эзэмшсэн мэдлэг, ур чадварын, төгсөлтийн үнэлгээг түншлэгч талтай	Улсын төсөв:	Мэргэжлийн төгсөлтийн үнэлгээний үр дүн, гүйцэтгэлийн дундаж хувь	88%	90%	Өвлийн 2.5 жилийн Мэргэжлийн төгсөлтийн үнэлгээний үр дүн: Онол-92%	100%

	хамтран зохион байгуулна.		Ерөнхий эрдмийн судлагдахуун бүрийн үр дүн, дундаж хувь	67%	70%	Ур чадвар-88%	
1.2.6	Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрүүдийг А/49 тоот индекс нийцүүлэн түншлэлийн оролцоог хангаж шинэчлэн боловсруулах	Улсын төсөв: 3500.0	Ажил мэргэжлийн стандартад нийцсэн мэргэжлийн болон техникийн боловсрол, мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн тоо Нийт хөтөлбөрт ажил мэргэжлийн стандартад нийцүүлэн боловсруулсан хөтөлбөрийн эзлэх хувь Түншлэгч талуудын оролцоог хангаж боловсруулсан хөтөлбөрийн тоо, тайлан	4 36% 11	100%	Мэргэжлийн болон Техникийн боловсролын мэргэжлийн чиглэл индексийг батлах тухай А/49 дугаар тушаалд нийцүүлэн 3 жилийн сургалттай 5 мэргэжлийн хөтөлбөр, 1 жилийн сургалттай 6 мэргэжлийн нийт 11 хөтөлбөрийг ажил олгогч мэргэжлийн багш нартай хамтран шинэчлэн боловсруулж, хөтөлбөр бүрт 3 ажил олгогчийн төлөөллөөр дүгнэлт гаргуулан сургуулийн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, сургуулийн захирлаар баталгаажуулан хичээл сургалтад ашиглаж байна.	100%
1.2.7	Иргэнд мэргэшил болон ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж, мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг нэмэгдүүлнэ. /ХММО/	Улсын төсөв:	Мэргэжлийн сургалтаар суралцаж, чадамжийн гэрчилгээ авсан төгсөгчийн тоо Үүнээс зорилтот бүлгийн өрхийн боловсролгүй, ажил эрхлээгүй (өрхийн тэргүүлэгч, насанд хүрсэн гишүүд) иргэдийн тоо Үүнээс орчин үеийн технологи	0 0	2	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж 15 гаруй ААН, Уул уурхай, 300 суралцагч, 200 гаруй ажилгүй иргэдээс авч судалгааны үр дүнд үндэслэн Мэргэжлийн	100%

			ашиглах ур чадвар эзэмшсэн иргэдийн тоо хөтөлбөрийн тоо, үр дүн, тайлан	11		боловсрол олгох 1 жилийн сургалттай Уул уурхайн ашиглалт мэргэжлээр шинэ мэргэжил нээх хүсэлтийг холбогдох журмын дагуу боловсруулан www.license.mn сайтад оруулсан.	
1.2.8	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах	Улсын төсөв: 2000.0	Суралцагч-1000 Иргэд 100-с доошгүй	Суралцагч-800, иргэн - 85	100%	- 2025.04.28-29-ны өдрүүдэд сумын ЕБС-ийн 6 бүлгийн 200 гаруй суралцагч, тэдгээрийн асран хамгаалагч, багш нарт нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, АМЧБО сургалтыг зохион байгууллаа. - Мөн 2025.04.29-2025.05.10-ны өдрүүдэд Улаанбаатар хотын 3 дүүргийн 13 сургууль, Хэнтий, Дорноговь аймгийн 15 сумын ЕБС-ийн удирдлага, багш ажилтнууд, нийт 2100 орчим сурагчдад мэргэжил сурталчлах, АМЧБО сургалтуудыг явуулж, 2025-2026 оны элсэлт сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.	100%
1.2.9	Сургуулийн веб сайтыг шинэчлэх	Улсын төсөв: 500.0	Сургуулийн вэб сайтыг сайжруулан, тогтмол ажиллагаанд оруулан	80%	100%	https://bor-undur.tvet.gov.mn/ веб сайтыг 2025 оны 1 сард	90%

			мэдээллийг ил тод нээлттэй хүргэнэ.			шинэчлэн, сайжруулалт хийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Сургуулийн ерөнхий мэдээлэл, хөтөлбөрийн мэдээлэл, элсэлт сурталчилгааны маркетингийн ажил, зохион байгуулагдаж буй ажлын мэдээллүүдийг тогтмол оруулж байна.	
1.2.10	Статистик мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой гарган холбогдох газарт хүргүүлж ажиллах.	Улсын төсөв: 100.0	Мэдээ - 11	100%	100%	Батлагдсан маягтын дагуу статистик мэдээнүүдийг хугацаанд хүргүүлсэн. Өвлийн төгсөлтийн статистик мэдээ, 2024-2025 оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээ, тэтгэлгийн мэдээ, 2025 оны 02 сарын төгсөлтийн мэдээг цаг хугацаанд нь БЕГ-т мэйлээр, аймгийн Боловсролын газарт цаасаар хүргүүлж ажилласан.	100%
Зорилт 1.3. Түншлэлийг хэрэгжүүлэх, гадаад, дотоодын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагатай эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу хамтран ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байгаль орчинд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх;							
1.3.1	Стратеги төлөвлөгөө, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд түншлэлийг хэрэгжүүлэх 1 жилийн төлөвлөгөө	Улсын төсөв:	Батлагдсан төлөвлөгөө, хэрэгжилтийн хувь, тайлан	70%	90%	- Манай сургуулийн гол түншлэгч болох Бор-Өндөрийн УБҮ-тэй хамтран ажиллах санамж бичгийг 2025.02.20-ны өдөр	85%

	боловсруулж, хэрэгжүүлнэ.					шинэчлэн байгуулж 9 чиглэлээр хамтран ажиллахаар болсон байна. - 2025.02.21-ний өдөр Бор-Өндөр суман дахь Онцгой байдлын хэлтэстэй Сургалтын хамтын ажиллагааны түншлэлийн гэрээ байгууллаа. Гэрээний хүрээнд алба хаагчдыг сургалтад хамруулж мэргэжил эзэмшүүлэх болон гамшгаас хамгаалах, ХАБЭА-н чиглэлээр хамтран ажиллахаар боллоо. - Техник Технологийн Политехник Коллеж, Техник Технологийн Дээд Сургуулийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлийн хүрээнд хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлд туршлага судлах үйл ажиллагааг дэмжиж 2025.03.25-ны өдөр харилцан ойлголцож хамтын ажиллагааны гэрээг үзэглэлээ. - 2025.03.24-ны өдөр Хэнтий аймгийн “Харгуй” ТӨХК-тай Сургалтын	
--	------------------------------	--	--	--	--	---	--

						хамтын ажиллагааны түншлэлийн гэрээ байгуулж, суралцагчдыг дадлагад хамруулах, төгсөгчдийг ажлын байранд зуучилж ажиллахаар болсон байна. Бор-Өндөр (Уул уурхайн коллеж), (МСҮТ), (МБС)-ийн ТӨГСӨГЧИЙН нэгдсэн фейсбүүк группийг нээж, төгсөгчид хоорондоо харилцаж, мэдээлэл солилцох, хамтран ажиллах, бие биеэ дэмжих боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Түншлэлийг хэрэгжүүлэх 1 жилийн ажлын төлөвлөгөөний биелэлт 85%- байна.	
1.3.2	Гадаадын их дээд сургууль, коллежтой хамтын ажиллагааны гэрээ байгуулж туршлага судлах	Улсын төсөв	Хамтран хэрэгжүүлсэн хөтөлбөрийн тоо, үр дүн, тайлан Туршлага судлах үйл ажиллагааны тоо, үр дүн, тайлан	3	80%	ӨМӨЗО-ны Ажил мэргэжлийн сургуулиудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж <u>Хятад</u> Монгол улсын мэргэжлийн боловсролын салбарын “ЦОГЦ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГ”-ийн гишүүн сургуулиар сонгогдон багш, суралцагч солилцоо хөтөлбөрийн хүрээнд: Бугат хотын Ажил	100%

						мэргэжлийн сургуульд богино хугацааны ур чадвар дээшлүүлэх сургалтад 2025.05.06-2025.05.26-ны өдрүүдэд Гагнуурын мэргэжлийн 1 багш 10 суралцагч, Цахилгааны мэргэжлийн 1 багш 8 суралцагч амжилттай хамрагдан сертификат гардан авсан.	
1.3.3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байгаль орчинд ээлтэй сургалтын орчин бүрдүүлнэ. (Дадлагын байрны газардуулгыг шинээр хийж холбох, эрсдлийн үнэлгээ хийнэ)	Улсын төсөв: 18000.0	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн албан ёсны эрх бүхий байгууллагын дүгнэлт, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан Дадлагын тоног төхөөрөмжийн гэрчилгээ, лицензийн тоо Байгаль орчинд ээлтэй байдлын дүгнэлт	70% 0% 43%	85%	- 2025.02.24-ны өдөр байгууллагын багш ажилчдад Аюул ба Эрсдэл сэдэвт сургалтад 44-30 багш ажилтан хамрагдаж, сургалт орсон сэдвээр мэдлэгийг баталгаажуулж шалгалт авч үр дүнг нэгтгэхэд гүйцэтгэл 100% байсан. - Сургуулийн захирлын 2025 оны 03 сарын 13-ний өдрийн А/24, А/25 тоот тушаалуудаар ХАБЭА-н орон тооны бус зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг шинэчлэн байгуулж төлөвлөгөө гарган ажиллаж байна. - 2025.03.19 Бор-Өндөр сумын ЗДТГ-н 21 албан хаагчдад нийт ажилтны 8	90%

						цагийн сургалтыг зохион зохион байгуулж сургалтын төгсгөлд шалгалт авч хичээлийг дүгнэсэн. - 2025.03.31 Хот тохижилтын 25 албан хаагчдад нийт ажилтны 8 цагийн сургалт орсон. Сургалт орсон сэдвээр мэдлэгийг баталгаажуулж шалгалт авч Гэрчилгээ олгосон. - Дадлагын байрны газардуулгыг бүрэн холбож Перфект солюшн энд инженеринг ХХК-р Ом тогтоолгож стандартыг хангаж ажилласан. - Хичээлийн төв байр-42.5% дунд эрсдэлтэй, Дотуур байр 22.9% бага эрсдэлтэй, Автын засварын дадлагын газар 54.9% өндөр эрсдэлтэй, Гагнуур, токарийн дадлагын газар 46.1% дунд эрсдэлтэй тус тус үнэлэгдсэн. Эрсдэлийн арилгах төлөвлөгөө	
--	--	--	--	--	--	--	--

						боловсруулан ажиллаж байна.	
1.3.4	Жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй сургалтын бүрдүүлнэ. орчин	Улсын төсөв: 20000.0	Сургуулийн дүрэм журам, хөтөлбөр, сургалтын агуулгад гарсан өөрчлөлтийн судалгаа, Үйл ажиллагааны тоо, хамрагдсан хүний тоо (хүйсээр) Үр дүнгийн тайлан Жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэлт нийт хөтөлбөрт эзлэх хувь	30%	90%	Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт II” төслийн хүрээнд сонгогдсон 20 мэргэжлийн боловсролын сургуулийн нэг болж “Оролцоонд суурилсан жендерийн аудит зохион байгуулах аргачлал” сургалтад Сургалтын менежер Э.Ганчимэг, ДЧБСМХА А.Зоригт нар хамрагдаж сургууль дээрх ажлын хэсэг тус төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Сургуулийн хэмжээнд мөрдөгдөж байгаа нийт 28 бичиг баримтад аудит хийж дүгнэлт гаргасан мөн сургуулийн 38 /үүнээс 11 эрэгтэй/ багш ажилчид, 98 үүнээс эмэгтэй 11 суралцагчид, 5 ажил	100%

						олгогчдоос судалгаа асуулга авч, орчны дүн шинжилгээг хийж тайлан боловсруулсан мөн ойрын 2 жилийн хугацаанд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан төсөлд хүргүүлсэн.	
1.3.5	Бор-Өндөр үйлдвэр технологийн парк /жонш, цахиур боловсруулах/ цогцолбор байгуулах төсөлд хамтран ажиллах санал хүргүүлэх	Улсын төсөв:	Эрдэнэс монгол нэгдлийн ҮТП-ын нэгжид хамтран ажиллах санал хүргүүлэх мөн ажиллах хүчнийг бэлтгэх мэргэжлийн хөтөлбөрийг тодорхойлсон байна. Уулзалт-1, судалгаа-1	30%	80%	2025 оны 05 сарын 21-нд Сургуулийн захирал, НТҮСХАЗ нар Эрдэнэс ҮТП-н гүйцэтгэх захирал Н.Мөнх-Идэр, Үйлдвэрлэл, технологи, Төсөл хөгжүүлэлтийн газрын менежер Г.Ганхуяг нартай уулзалт хийн хамтран ажиллах санал хүргүүлсэн. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулахтай холбоотой хэрэгжиж буй төслүүдийн хүний нөөцийн хэрэгцээ, цаашид уул уурхай болон зам, тээврийн бүтээн байгуулалтын үр дүнд үүсэх ажлын байрны эрэлтийг судалж 2028 онд ажиллах хүчний тодорхой хувийг бэлтгэхээр харилцан тохиролцов. 2025 оны 6 сарын эхний 7 хоногт хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаар болсон.	100%

Зорилт 1.4. Байгууллагын хүний нөөцийн удирдлага, багшийн хөгжлийг тасралтгүй хангах, чадавхыг бэхжүүлэх,

1.4.1	Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн үр дүн, бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангах.	Улсын төсөв: 17100.0	Нийт төсөвт эзлэх багшийн хөгжлийн зардлын хувь Багшийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө, биелэлтийн хувь Багш, ажилтны хөгжлийг сургууль бодлогоор дэмжсэн үйл ажиллагааны биелэлтийн хувь Багш, ажилтны тоо: Сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсэн мөнгөн дүн: гэх мэт	Магистрын сургалтад хамрагдсан 7 багшийн төлбөрт 9000.0 мян.төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мэргэжлийн 3 багшид тус бүр 10 өдрийн чөлөө олгосон.	Мөнгөн дэмжлэг үзүүлсэн, багш, ажилтны тоо 7, 43% Бусад дэмжлэг үзүүлсэн багш, ажилтны тоо 5-с доошгүй Нийт багш, ажилтныг хөгжүүлэхэд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь 100%	- Багшийн хөгжлийн хөтөлбөр 2022-2026 хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 2024-2025 оны хичээлийн жилд 6 багш магистрын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж байна. Мөн энэ хичээлийн жилд шинээр 2 багш ТТПК-д багш мэргэжлийн боловсрол хөтөлбөрийн магистрын хөтөлбөрт хамрагдаж байна. Сургуулийн дотоод журамд заасны дагуу магистрын хөтөлбөрт хамрагдаж буй багш нарт цалинтай чөлөө болон төлбөрийн дэмжлэгийг үзүүлж байна. - 2025.04.04,25-ны өдрүүдэд МУБИС-ийн багш, докторант Б.Энхжаргал багшийг урьж нийт багш, сургалтын албаны ажилчдад “Сургалтын идэвхтэй аргууд”	90%
-------	---	----------------------	--	--	---	---	-----

						сэдвээр сургалт, семинар зохион байгууллаа. Мөн нийт багш нарт 100 арганыг авч хичээл сургалтад ашиглаж байна. - БЕГ-с зохион байгуулсан багшлах эрхийн сургалтад багш Д.Долгор, Ц.Баттулга, С.Тунамал нар хамрагдан, амжилттай төгссөн. Багш нарын сургалтын төлбөрт 3.084.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	
1.4.2	“SHARE EXPERIENCE” Мэргэжлийн боловсролын сургуулиуд, уул уурхайн үйлдвэр, аж ахуйн нэгжид мэргэжлийн болон ерөнхий эрдмийн багш нар туршлага судалж, тус хөтөлбөрийг хэрэгжүүлсэн	Улсын төсөв: 8490.0	Туршлага судлах үйл ажиллагаа - 5 Багш инженер солилцоо хөтөлбөр-1 зохион байгуулсан байна.	80%	100%	2025.03.24-26-ны өдрүүдэд Манай сургуулийн Чанарын удирдлагын тогтолцооны баг ТТПК, ҮҮПК, Төв аймаг дахь ПК, Говьсүмбэр аймаг дахь ПК-ийн чанарын удирдлагын менежмент нэвтрүүлсэн сайн туршлагаас туршлага судлан хамтран ажиллах гэрээ байгууллаа. Мөн 2025.04.16-19-ны өдрүүдэд 15 хүний бүрэлдэхүүнтэй баг Өмнөговь ПК-ийн үйл	90%

						ажиллагаатай танилцан тэдний сайн туршлагаас судаллаа. Дорнод ПК-н нээлттэй зохион байгуулсан Монгол ур чадварын 1-р шатны шалгаруулалтад 2 багш, 3 суралцагч зочин оролцогчоор оролцсон. Налайх ПК-д 2025.04.14-04.19 -ний өдрүүдэд Монгол ур чадвар уралдааны сургуулийн шатнаас шалгарсан оролцогчид ХАМТАРСАН бэлтгэлийг хийж харилцан туршлага солилцлоо.	
1.4.3	Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn мэдээллийн санд нийт албан хаагчдын мэдээллийг тухай бүр оруулах.	Улсын төсөв	Нийт багш, ажилтан албан хаагчдын мэдээллийг тухай бүр үнэн зөв оруулсан байна.	90%	100%	Монгол улсын төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан зөвлөн туслах ажлын зөвлөмжийн дагуу бүх албан хаагч нарын анкетыг өөрсдөөр нь баталгаажуулалт хийлгэж өөрчлөлтүүдийн мэдээллийг оруулсан.	90%
1.4.4	Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах.	Улсын төсөв	Батлагдсан бүтэц орон тооны дагуу шинэ багш, ажилтныг сонгон шалгаруулах журмын дагуу ил тод нээлттэй зарлаж дутагдалтай орон тоог нөхөж ажиллана.	81%	90%	Дутагдалтай орон тооны зарыг сургуулийн раге хуудас болон Бор-Өндөр сум Төрийн мэдээллийн цахим хуудсаар дамжуулан нийтэд түгээж ажилласан. Мөн Бор-Өндөр сумын Хөдөлмөр эрхлэлт, халамж хариуцсан мэргэжилтэнд	90%

						сул орон тооны мэдээллээ сар болгоны 10-нд хүргүүлж ажиллаж байна.	
1.4.5	U-TVET сургалт удирдлагын нэгдсэн системийг ашиглах	Улсын төсөв	Цахим сургалтын систем - 1	50%	100%	U-TVET сургалт удирдлагын нэгдсэн системд сургуулийн нийт багш суралцагчдын мэдээллийг оруулж, хичээл сургалтад ашиглаж байна.	90%
Зорилт 1.5. Суралцагч, төгсөгчдийн хандлага, төлөвшил, зан үйлийн харилцаанд зэрэг өөрчлөлтийг бий болгоход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах							
1.5.1	Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	Улсын төсөв: 1000.0	Арга хэмжээ – 3-с доошгүй зохион байгуулсан байна	50%	80%	- Сургууль дээрх хүүхэд хамгааллын багийг байгуулан төлөвлөгөө гарган 7 хоног бүр сургуулийн нийт суралцагчид болон дотуур байрны суралцагчдад сургалт, хүмүүжлийн ажлыг тогтмол зохион байгуулж байна. Үүний хүрээнд: - Сургууль дээр гэрээгээр сэтгэл зүйч ажиллуулж 7 хоног бүрийн лхагва гараг бүр сэтгэл зүйн зөвлөгөөг өгч байна одоогийн байдлаар 34 суралцагч сэтгэл зүйн зөвлөгөө авсан байна. - Хүүхэд хамгааллын	80%

						тухай хуулийг нийт эцэг эх, суралцагчдад сурталчлан таниулах сургалт зохион байгуулсан. 24 эцэг эх, 140 суралцагч хамрагдсан. - 2025 оны 04 дүгээр сарн 04-нд Бор-Өндөр сумын Сум дундын прокурорын газраас гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөмжийг авч нийт 195 суралцагч хамрагдсан.	
1.5.2	Соёл хүмүүжлийн ажлыг нэгдсэн төлөвлөгөө, графикийн дагуу зохион байгуулах	Улсын төсөв: 5000.0	Тэмцээн уралдаан – 16, соёл хүмүүжлийн ажил – 10 удаа зохион байгуулсан байна.	22 уралдаан тэмцээн	100%	- Сургуулийн нийт охидын дунд 2025.03.14-нд Охидын өдөрлөгийг зохион байгуулж Бор-Өндөр сумын Сум дундын Нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүдийн Их эмч Н.Бадамханд сургалт хийж мэргэжлийн зөвлөгөө өгсөн. - Сургуулийн нийт хөвгүүдийн дунд 2025.03.18-нд Бор-Өндөр сумын Сум дундын Онцгой байдлын хэлтэстэй хамтран “Өсвөрийн	80%

						аврагч” тэмцээнийг зохион байгуулсан. Нийт 8 бүлгийн 8 баг хамрагдсан. - Илтгэх урлагийн дугуйлангийн суралцагчдын дунд 2025.02.11-нд харилцаа ба хандлага сэдвээр илтгэлийн уралдаан зохион байгуулж нийт 15 суралцагч оролцсон. - Сургуулийн аварга шалгаруулах Үндэсний бөхийн барилдаан мөн Гар барилдааны тэмцээнийг тус тус зохион явууллаа. - 2025.03 сард Бидний бүтээсэн хамгийн сайн дүр Фото зургийн уралдаан. - 2025.03.07-нд Цагаан сар арга хэмжээг нийт суралцагчдын дунд зохион байгуулсан. - 2025.03.16-нд Яг түүн шиг- Монголын зохиолчдыг хэн сайн дуурайх вэ? Уралдаанд 26 суралцагч хамрагдсан. - Дотуур байрны суралцагчдад 7 хоног бүр сургалт, хүмүүжлийн ажлыг	
--	--	--	--	--	--	--	--

						зохион байгуулж байна. - 2025.04 сард Алтан хонх тэмцээнийг зохион байгуулсан. Нийт 65 суралцагч оролцсон. - Сургуулийн аварга шалгаруулах 3х3 Сагсан бөмбөгийн тэмцээнийг 2025.05.22-нд амжилттай зохион байгуулж шилдгүүдээ тодруулсан. - Мэргэжлийн боловсролын сургалтын 3 жилийн эрэгтэй суралцагчдын дунд E-sport, Mobile Legends Bang Bang тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Нийт 9 баг оролцлоо. 2025.05.29-нд Мэргэжлийн боловсрол олгох сургалтын нийт ангиудын дунд “Банштай цай-Байгалиа хайрлая” явган аяллыг зохион байгууллаа. Нийт 8 бүлгийн 140 суралцагч багш ажилчид хамрагдлаа. 2025.05.30-нд Хэнтий аймгийн ХХҮГ, Вест мэтод хөгжил ХХК-тай хамтран	
--	--	--	--	--	--	--	--

						зохион байгуулсан Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтад нийт 60 суралцагч хамрагдсан.	
1.5.3	“Найрсаг харилцаа-ээрэг хандлага” зорилтот жилийн хүрээнд суралцагчдын дунд сургалт, нөлөөллийн ажил зохин байгуулах	Улсын төсөв: 10000.0	Сургалт- 2 Нөлөөллийн арга хэмжээ - 2-с доошгүй удаа зохион байгуулсан байна.	2 сургалт	100%	"НАЙРСАГ ХАРИЛЦАА - ЭЕРЭГ ХАНДЛАГА" зорилтот жилийн хүрээнд: Нийт багш ажилтан, суралцагчдын дунд мэндлэх хүндлэх сарын аян, нэгэндээ сэтгэлийн үгээ илэрхийлэх талархлын булан, багш суралцагчдын дунд чөлөөт ярилцлагыг тус тус зохион байгууллаа. Мөн нийгмийн ажилтан Д.Мөнхдэлгэр нийт суралцагчдад “Хандлагаас хандлага-Харилцаанаас харилцаа” сэдвийн хүрээнд сургалт хэлэлцүүлэг зохион байгуулав. Нийт 180 суралцагч хамрагдлаа. Мэргэжлийн боловсрол олгох 3 жилийн сургалтын 8 бүлгийн ангийн дарга нартай сургуулийн захирал 2025.05.15-нд уулзаж санал солилцож цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд саналуудыг тусгалаа. Суралцагчийн Ёс зүйн	80%

						дүрмийг боловсруулж баталсан.	
Зорилт 1.6. Батлагдсан төсөв, өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогыг үр ашигтай зарцуулах, багш, ажилтан, суралцагчийн эрүүл аюулгүй таатай орчинд сурч хөгжих, ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;							
1.6.1	Сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт шинжилгээ хийлгэх	Улсын төсөв: 1300.0	Аудитын тайлан	Өөрчлөлтгүй	2024 онд Төсвийн зарцуулалтад аудит хийлгэж, хангалттай үнэлгээ авсан байна.	Платиниум прогресс аудит ХХК нь 2024 оны санхүүгийн тайланд хяналт шинжилгээ хийн Өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Зөвлөмжийн биелэлт 100%-тай байна.	100%
1.6.2	Нэг суралцагчид ногдох зардал хувьсах	Улсын төсөв: 6442.0	Нэг суралцагчид ногдох хувьсах зардал (өртөг)	5925.0	6442.0	2025 онд Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нэг суралцагчид ноогдох хувьсах зардалд үндэслэн олгох санхүүжилт 2158151.7 мянган төгрөг байна. Эхний хагас жилийн гүйцэтгэл 42.5% буюу 917641.1 мянган төгрөг	75%
1.6.3	Монгол ур чадварын сургуулийн шатны уралдааны зардлыг төсөвт тусган, хэрэгжилтийг тайлагнана.	Улсын төсөв: 3000.0	Монгол ур чадварын уралдааны дүрэм, жумын дагуу зохион байгуулах. Уралдаан тэмцээн -1	Сургууль дээрх уралдаан-1	100%	Монгол ур чадвар сургуулийн шатны уралдааныг Гагнуур, Металлурги, металлын технологи, Уул уурхайн машин механизмын угсралт, засвар үйлчилгээ, Цахилгаан хангамж, тоног	100%

						төхөөрөмжийн ашиглалт гэсэн 4 мэргэжлээр 2 болон 3-р ангийн нийт 89 суралцагчид хоёр өдөр өрсөлдөж шилдгүүдээ тодруулсан. Мөн 2025.04.21-25-ны өдрүүдэд Монгол ур чадвар уралдааны 2-р шатанд бэлтгэж байгаа суралцагч Б.Даваажаргал, А.Есүхэй, Б.Эрдэнэбат нарыг Налайх дүүрэг дэх ПК дээр 5 хоногийн хугацаанд дадлагажууллаа.	
1.6.4	Дотуур байрны суралцагчдын орчин нөхцөл, үйлчилгээний төрөл, чанарыг сайжруулах.	Улсын төсөв: 20000.0	Дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх, Тасгуудын урсгал засварыг хийх, Дотуур байрны зөөлөн эдлэлийг солих,	Засварын ажил-3 Тохижилтын ажил- 3	100%	- 2024 оны 12-р сарын 30-ны өдрийн 254-р тогтоолоор 2025 оны Захирлын А/05 тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, дотуур байрны суралцагчдын хоол хүнсээр авбал зохих илчлэг, шим тэжээлийн хэмжээ, хоолны орц, найрлага сайжруулах чиглэлийн дагуу хоолны цэс шинэчлэх, технологийн карт боловсруулж, хоолны иж бүрдлийн аяга-60ш таваг-80ш захиалан авч, хэрэглээндээ нэвтрүүлсэн байна.	90%

						- Дотуур байрны гал тогоонд 1-р хоолны тогоог засварлаж хэвийн ажиллагааг хангаж, буузны жигнүүр, 600л багтаамжтай хөргөгч, дээжийн хөргүүр зэргийг шинээр авч тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн. - Дотуур байрны гадна хаалганд металл хаалт хийж тохилог дулаан орчин бүрдүүлж, суралцагчид гутлаа тайлж орох нөхцөл боломжоор хангаж гутлын шүүгээг хийж байрлуулсан. - Дотуур байрны суралцагчдын номын санд SAMSUNG телевизор /70 инч/ байрлуулсан - Дотуур байрны суралцагчдын кофены буланг байгуулсан.	
1.6.5	Хичээлийн төв байрны гаднах гэрлэн хаяг, дадлагын байр, дотуур байрны металл хаягийг шинэчлэн солих	Улсын төсөв: 6000.0	Хаяг – 4 ширхэг	-	100%	Хичээлийн төв байрны гаднах гэрлэн хаягийг ЭРДЭНЭ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ-оор гүйцэтгүүлсэн. Хичээлийн төв байр, дадлагын байр, дотуур	100%

						байрны металл хаягуудыг MNS:5283:2022 стандартын дагуу хаягжуулалт хийж шинэчлэн сольсон.	
1.6.6	Хичээлийн төв байрны инженерийн шугам сүлжээг шинэчлэх	Улсын төсөв: 273000.0	Худалдан авах ажиллагааны журмын дагуу инженерийн шугам сүлжээний засварын ажлыг зохион байгуулсан байна. Тендер – 1	20%	100%	Хэнтий аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/630 дугаар захирамжаар 2025 оны Хэнтий аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Мэргэжлийн боловсролын сургуулийн хичээлийн төв байрны инженерийн шугам сүлжээний засварын ажилд 273.8 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдсэн. Уг ажлын гүйцэтгэгчээр “Ашид бьюлдинг” ХХК шалгарч, гэрээний дагуу ажлыг хугацаанд нь бүрэн гүйцэтгэсэн. 2025.04.17-ны өдөр ажлын хэсэг хүлээж авсан.	100%

1.6.7	Багш, албан хаагч суралцагч нарт зориулсан буфетны үйл ажиллагааг тогтмол явуулах	Улсын төсөв:	Эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр үйлчлэх	50%	100%	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажлын ая тухтай орчин бүрдүүлэх зорилгоор сургуулийн номын санч Ц.Дэлгэрмаад буфетийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй ашиглах боломжийг олгож, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлэн ажиллуулсан. Буфетийн үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлэхийн тулд багш, албан хаагч, суралцагчдыг эрүүл, амт чанартай хоол хүнсээр тогтмол хангах зорилгоор хоёр тал гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Уг арга хэмжээ нь байгууллагын дотоод нөөцийг үр ашигтай ашиглаж, албан хаагчдын өдөр тутмын хэрэгцээг хангах, суралцагчдын сургалтын орчныг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулахад чиглэсэн бодит дэмжлэг	100%
-------	---	--------------	--	-----	------	--	------

						болсон.	
1.6.8	Металлурги металлын технологи болон Цахилгаан хангамж тоног төхөөрөмжийн ашиглалт мэргэжлүүдийн онолын 2 танхим засварлаж, ашиглалтад оруулах	Улсын төсөв: 20000.0	Сургалтын орчин сайжирсан байна. Анги танхим - 2	30%	100%	Металлурги металлын технологи, Цахилгаан хангамж тоног төхөөрөмжийн ашиглалт мэргэжлүүдийн онолын танихмуудын засвар үйлчилгээнд шаардлагатай төсөв тооцооллыг гаргаж, анги танхимын халаалтын шугамуудыг шинэчлэн засварласаж өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан засварын ажлыг эхлүүлээд байна.	90%
1.6.9	Хэвлэлийн график дизайн, бүтээгдэхүүний мэргэжлийн дадлагын газрыг шинээр байгуулах	Улсын төсөв: 20000.0	Дадлагын газар - 1	50%	100%	Хэвлэлийн график дизайн, бүтээгдэхүүний үйлдвэрлэл мэргэжлийн чиглэлийн суралцагчдын дадлага, үйлдвэрлэлийн орчныг бүрдүүлэх зорилгоор мэргэжлийн дадлагын газрыг шинээр байгуулах ажлыг эхлүүлсэн. - Дадлагын газрын зориулалтын өрөө,	90%

						талбайг сонгон тохижуулах шийдвэр гаргасан - Шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний судалгаа, тооцооллыг боловсруулан худалдан авсан.	
1.6.10	Улсын төсвийн санхүүжилтээр 2025 онд худалдан авах ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулах	Улсын төсөв: 439037.7	Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн зарлаж шалгаруулсан байна. Тендер - 2	-	100%	- Дотуур байрны хоол хүнс нийлүүлэх тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарлан тендер шалгаруулалтад нэг компани оролцсон ба “Пүрдэм” ХХК-тай дотуур байрны хоол, хүнсний материал нийлүүлэх гэрээг 2025 оны 04 сарын 22-ны өдөр 110720516 төгрөгөөр байгуулан ажиллаж байна. - Мэргэжлийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын бэлдэц материал нийлүүлэх тендерийг харьцуулалтын аргаар зарлан Бренд Теч Бридж ХХК шалгаран	100%

						2025 оны 04 сарын өдөр 50620800 төгрөгөөр гэрээ байгуулан ажиллаж байна.	
1.6.11	Батлагдсан төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах	Улсын төсөв: 2.377.52 0.2	Төсвийн төлөвлөлт зарцуулалтын ил тод байдлыг хангаж ажилласан байна.	-	100%	2025 онд Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардалд үндэслэн 2,158,151.7 (хоёр тэрбум нэг зуун тавин найман сая нэг зуун тавин нэг) мянган төгрөг-ийн санхүүжилт батлагдсан болно. Эхний хагас жилийн гүйцэтгэлээр: - Санхүүжилтийн гүйцэтгэл 42,5%, буюу 917641.1 мянган төгрөг байна. - Үүнээс зарцуулалт 807248.8 мянган төгрөг, буюу 87,97%-ийн гүйцэтгэлтэй байна.	88%

1.6.12	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Улсын төсөв:	Мэдээ - 171	-	100%	2025 оны эхний 5 сарын байдлаар нийт 52 мэдээ, тайланг info.shilendans.gov.mn системд хугацаанд нь тайлагнаж бүртгүүлсэн байна. Тайлангуудыг холбогдох журам, удирдамжийн дагуу боловсруулан, цахим системд оруулж ажилласан бөгөөд байгууллагын ил тод, нээлттэй байдал, тайлагналын сахилга бат сайжирч байна.	60%
ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 2.1. Гэмт хэрэг, зөрчил, аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр багш, ажилтан, иргэд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;							
2.1.1	Авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах.	Улсын төсөв: 2000.0	Сургалт -2	100%	100%	Бор-Өндөр Сум дундын прокурорын газрын өмгөөлөгч Э.Номин-Эрдэнэ 2025.04.22-ны өдөр “Авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх сургалт”-ыг нийт багш ажилчдад зохион байгуулсан. Цахим орчинд авлигын эсрэг мэдээ мэдээллийг	80%

						тогтмол түгээж ажиллаж байна.	
2.1.2	Төрийн албан хаагчийн болон багшийн ёс зүй нэр төрийг эрэхмлэн сахин ажиллаж, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх.	Улсын төсөв: 500.0	Байгууллагын ёс зүйн дэд хороо нь төлөвлөгөө гарган ажилласан байна. Журам -1, дүрэм - 1	100%	100%	1. Орон тооны бус “Ёс зүйн дэд хороо”-ны гишүүдийг 2025 оны 02 сарын 07-ны өдрийн хамт олны хурлаар сонгосон бөгөөд 02 сарын 19-ний өдрийн Захирлын А/15 тоот тушаалаар баталсан. 2. Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөг 03 сарын 12-ны өдөр Сургуулийн захиралд танилцуулан, Ёс зүйн дэд хорооны даргаар батлуулсан. 3. Ажлын төлөвлөгөөний дагуу 02 сарын 24-ний өдөр “Ёс зүйн дэд хорооны дүгнэлт” албан бланкаа захиалж авсан. 4. Байгууллагын хэмжээнд 2024 оны 11 сарын 13-ны өдөр Захирлын А/47 тоот тушаалаар батлагдсан “Сургалтын байгууллагын багш, ажилтны ёс зүйн дүрэм”-г үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. 5. 05 сарын 06-ны өдөр “Сурагчийн баримтлах ёс зүйн дүрэм”-ийн төслийг боловсруулсан. 6. 05 сарын 19-ний өдөр	90%

						Байгууллагын багш, ажилтнуудад зориулсан ёс зүйн зөвлөмж, уриалгыг бэлтгэн цахим орчинд байршуулсан.	
2.1.3	“Найрсаг харилцаа-ээрэг хандлага” зорилтот жилийн хүрээнд багш ажилчдын дунд сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах	Улсын төсөв:	Сургалт -2 Нөлөөллийн арга хэмжээ – 2 зохион байгуулсан байна.	50%	100%	Багш суралцагчид ажилчид хоорондын “Найрсаг харилцаа-ээрэг хандлага” зорилтот жилийн хүрээнд уур амьсгалыг бүрдүүлэхтэй холбоотойгоор сургуулийн багш ажилчид, суралцагчид “ТАЛАРХАЛЫН ХАЙРЦАГ АЯЛУУЛАХ” болон эвлэрлийн үгээ илгээх хандлагыг хэвшүүлэхийг зорьж ажиллаа. Ёс зүйн дэд хорооноос “Найрсаг харилцаа-ээрэг хандлага” зорилтот жилийн хүрээнд нийт багш ажилтнуудад Ёс зүйн зөвлөмж уриалга гаргасан.	80%
Зорилт 2.2. Эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааны чанарыг тасралтгүй сайжруулж, хурал, зөвлөгөөн зохион байгуулах							
2.2.2	Сургууль дээрх судалгаа инновац, төслийн багийг байгуулж, төлөвлөгөөний дагуу ажиллах	Улсын төсөв:	Багийн бүрэлдэхүүн-9 хүн Арга хэмжээ – 5с доошгүй	30%	80%	Бор-Өндөр МБС-ийн 2025.02.24-ны өдрийн А/19 дугаар тушаалаар Судалгаа инноваци, төслийн баг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, эхний хагас жилд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулан	70%

						ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 2022-2024 онд гарсан судалгааны ажил, илтгэлийн эмхэтгэлийг гаргах, Цахилгаан автомашиныг засварлах, хэвийн ажиллагаанд оруулах үйл ажиллагаа явагдаж байна. Мөн дуудлагын гагнуурын үйлчилгээг Бор-Өндөр сумын иргэдэд хүргэх ажлын хүрээнд Бор-Өндөр ЕБС-ийн сурагчдын эвдэрч хуучирсан ширээ сандлыг сэлбэх, засаж янзлах ажлыг 2-р ангийн сурагчдаар гүйцэтгүүлж байна.	
ГУРАВ. ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 3.1. Өөрийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтыг улирал бүр тайлагнах;							
3.1.1	Сургууль дээрх үйлдвэрлэлийн дадлагаар болон мэргэжлийн сургалтаар өөрийн үйл ажиллагааны орлого олж, сургалтын орчинг сайжруулах.	Улсын төсөв:	Өөрийн орлого - 5000.0	4600.0	100%	2025.03 сард Бор-Өндөр сумын ЗДТГ-н 21 албан хаагчдад нийт ажилтны 8 цагийн сургалтыг зохион байгуулсан. - 2025.03 сард Бор-Өндөр Хот тохижил ОНТҮГ-н 25 албан хаагчдад нийт ажилтны 8 цагийн сургалтыг мөн зохион байгуулсан. Дээрх 2 сургалтаар	90%

						1.000.000 төгрөгийн орлого олсон. Мөн жолооч бэлтгэх В ангиллын сургалтаар 8 иргэнийг сургаж сургалтын төлбөр болох 3.600.000 төгрөг өөрийн орлогыг бүрдүүлсэн. Өөрийн орлогоор дадлагын шинэ танхим засварлахаар тооцоо судалгаа гарган ажиллаж байна.	
Зорилт 3.2. Үндэсний ур чадварын талбарыг хөгжүүлэхэд төр хувийн хэвшлийн түншлэлийн хамтын үйл ажиллагааг манлайлах, олон талт оролцоог хангах механизмыг бүрдүүлэн ажиллах, сургуулийн аварга шалгаруулах уралдааныг журмын дагуу зохион байгуулах, суралцагч болон багш нарын оролцооны тэгш боломжийг хангах, сайжруулалтын төлөвлөгөө гарган ажиллах							
3.2.1	Үндэсний ур чадварын талбарыг хөгжүүлэхэд төр хувийн хэвшлийн түншлэлийн хамтын үйл ажиллагааг манлайлах, олон талт оролцоог хангах механизмыг бүрдүүлэн ажиллана.	Улсын төсөв:	Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэртэй хамтран сумын хэмжээнд 60 гагнуурчдын дунд ур чадварын уралдаан зохион байгуулна Уралдаан-1	-	100%	Бор-Өндөр УБҮ-тэй байгуулсан санамж бичгийн хүрээнд 2025 оны 04 сарын 10,11-ны өдөр Бор-Өндөр УБҮ болон Монголын материал судлал гагнуурын нийгэмлэгтэй хамтран сумын хэмжээнд “Гагнуурчин ур чадвар” 2025 уралдааныг амжилттай зохион байгуулж нийт 52 гагнуурчин оролцож шилдгүүдийг тодруулсан.	100%
3.2.2	Сургалтын байгууллагын уралдааныг журмын	Улсын төсөв: 10000.0	Багш нарын дунд заах аргын уралдааныг зохион байгуулах	80%	100%	Ерөнхий эрдмийн Монгол хэл, Үндэсний бичиг, Англи хэл, Хими,	80%

	дагуу зохион байгуулах, суралцагч болон багшийг тэгш оролцоот боломжоор хангах, сайжруулалтын төлөвлөгөө гарган ажиллах		Нийт суралцагчдын дунд ерөнхий эрдмийн хичээлээр олимпиад зохион байгуулна			Газарзүй, Нийгмийн хичээлүүдээр сургуулийн шатны олимпиад зохион байгуулж эхний шатанд тэнцсэн эхний 3-н суралцагчдыг МБТБСБ-ын улсын олимпиадад оролцуулсан. Амжилтуудаас дурдвал: - 2025.03.27-ны өдөр Эрдэнэ ПК-д зохион байгуулагдсан “Газарзүй”-н анхдугаар олимпиадад багш, суралцагч нар амжилттай оролцож багшийн төрөлд Э.Сүнжидмаа 3-р байр эзэлж “Хүрэл” медаль хүртсэн. - 2025.04.26-ны өдөр ҮУПК-д зохион байгуулагдсан Англи хэлний XXII олимпиадад багш, суралцагч амжилттай оролцож суралцагчийн төрөлд УУММУЗҮ-23а ангийн суралцагч Г.Мөнхбаясгалан амжилттай оролцон “Дэд” байр эзэлж, мөнгөн медаль хүртлээ. - МБТБСБ-ын улсын олимпиадад Монгол хэл, Үндэсний бичиг, Нийгмийн ухаан, Химийн хичээлийн	
--	--	--	---	--	--	---	--

						төрлөөр суралцагчдаа оролцуулсан.	багш бэлтгэн	
--	--	--	--	--	--	---	-----------------	--

ХОЁР. МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ:

Гэрээнд тусгагдсан манлайллын зорилт (орц), түүний шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл (шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин)	Тухайн манлайллын зорилтын биелэлтэд ТЕЗ-ийн өгсөн үнэлгээ (Зорилт бүрийн биелэлтэд 0- 100 хувь)
1	2	4
Зорилт-1: Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар:	➤ Байгууллагын албан хаагч, удирдлагын ёс зүйтэй холбоотой санал гомдол ирээгүй. ➤ Хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор ёс зүйн дэд хороо байгуулж, ёс зүйн дэд хорооны ажиллах журам, сургуулийн багш ажилтнууд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна. ➤ Иргэд, аж ахуйн нэгж, төрийн захиргааны төв байгууллага, байгууллагын албан хаагчдаас гомдол гараагүй ба хуулийг чанд мөрдөж зөрчил, дутагдалгүй ажилласан. ➤ Бор-Өндөр Сум дундын прокурорын газрын өмгөөлөгч Э.Номин-Эрдэнэ 2025.04.22-нд авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх сургалтыг нийт багш ажилчдад зохион байгуулсан.	100%
Зорилт-2: Байгууллагын ил тод байдлыг хангах талаар:	➤ Байгууллагын ил тод байдлын тухай самбар, цахим сайтаар байнга явуулж байна. ➤ Суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгааг 4 удаа авч судалгааны дүгнэлтэд үндэслэн төлөвлөгөө гарган ажилласан.	100%
Зорилт-3: Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга батыг сахин ажиллах:	➤ 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд Хэнтий аймгийн Төрийн аудитын газар аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт гаргасан. ➤ Санхүүгийн тайлан, баланс, 2025 оны төсвийн төслийг хууль тогтоомж, журмын дагуу урьдчилсан байдлаар гаргаж БЕГ-т хүргүүлсэн.	100%

Манлайллын зорилтын биелэлтийн ДУНДАЖ ОНОО:	100%
--	-------------

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ:

Гэрээний үзүүлэлт	Өгвөл зохих хувь	Өгсөн хувь /дундаж хувь/
1. Нийт арга хэмжээний биелэлт	100%	93%
2. Манлайллын зорилтын биелэлт	100%	100%
НИЙТ ХУВЬ	100%	96.5%

1	НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД	41 АЖИЛ
2	ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД	5 АЖИЛ
3	ГУРАВ. ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	4 АЖИЛ
4	МАНЛАЙЛАЛЫН ЗОРИЛТ	6 АЖИЛ

Боловсруулалтыг сайжруулах нийтлэг зөвлөмж

1. Зорилт нь үр дүнд суурилсан, бодитой, биелэгдэхүйц байх, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь зорилтдоо чиглэсэн
2. Арга хэмжээг хэрэгжүүлэх нөөц, төсөв, санхүүгийн эх үүсвэр тодорхой байх
3. Арга хэмжээний хүрэх түвшинг нэг болон түүнээс олон шалгуур үзүүлэлтээр хэмжигдэхүйц байхаар тодорхойлох
4. Шалгуур үзүүлэлтийг үр дүнд суурилсан, хэмжигдэхүйц байдлаар тодорхойлоход анхаарах
5. Тухайн арга хэмжээний хувьд өмнө нь ямар нэг ажил хийгдэж байгаагүй, эсхүл өдөр тутам хийгддэг арга хэмжээ байвал суурь түвшинг тодорхойлохгүй байж болно. Энэ тохиолдолд зураасаар (-) тэмдэглэнэ.
6. Статистик мэдээллээр, эсхүл тодорхой хугацаанд тогтмол хийгддэг судалгааны үр дүнгээр тодорхойлох боломжтой бол тухайн арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг эдгээр тоо болон бусад мэдээлэлд үндэслэн тодорхойлох
7. Арга хэмжээний хүрэх түвшинг шалгуур үзүүлэлт тус бүрээр хагас, бүтэн жилээр тодорхойлох.
8. Арга хэмжээний эхлэх дуусах хугацааг сараар тооцож бичнэ. Ж: 1, 2 дугаар сар, 9,10 дугаар сар гэх мэт
9. Арга хэмжээ дэд арга хэмжээнд хуваагдаж болно. Жишээ нь:
 - хөтөлбөр хэрэгжүүлэх гэсэн арга хэмжээ байхад
 - Бэлтгэл хангах
 - Чадавхжуулах сургалт зохион байгуулах
 - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх
 - Үр дүнг тайлагнах г.м Тус дэд арга хэмжээг хагас болон бүтэн жилээр тодорхойлж үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж болно.
10. Үр дүнгийн гэрээ, түүний хавсралт болох байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үг, үсэг, найруулга зүйн алдаагүй, MNS 5140-1 : 2021 стандартын нийцүүлэн боловсруулах

Бодлогын баримт бичигт туссан заалтыг харна уу.

Алсын хараа 2050 2.1.9, 2.1.10, 2.1.11, 3.1.15, 3.1.17, 4.1.19

2.1.9. Их, дээд сургууль, политехникийн коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургуулийг тухайн орон нутаг, бүс нутгийн хүний хөгжлийн төв болгон хөгжүүлж бүх насны иргэд, нийгмийн салбар бүрийг хамарсан насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцоог бэхжүүлнэ.

2.1.10. Их, дээд сургууль, политехникийн коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд төгсөгчдийнхөө мэргэжил дээшлүүлэх асуудлыг хариуцдаг тогтолцоог бий болгож, насан туршийн боловсролын үйлчилгээний чиглэлийг нэмэгдүүлэн, насанд хүрсэн суралцагчдын ажил эрхлэх ур чадвар, амьдрах чадварын сургалтын хүрээнд төдийгүй шинэ чадвар эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр бий болгож хэрэгжүүлэхэд олон талт оролцоог хангана.

2.1.11. Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

3.1.15. Зорилтот бүлгийн өрхийн боловсролгүй, ажил эрхлээгүй өрхийн тэргүүлэгч, насанд хүрсэн гишүүдийг мэргэжилтэй ажилтан болгох бодлогын хүрээнд мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг ахиулах сургалтад хамруулна.

3.1.17. Зорилтот бүлгийн өрхийн хүүхдийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамрагдах, боловсролтой болох боломжоор хангах, мэргэжлийн, дипломын сургалтын тэтгэлэгт хамруулах замаар ядуурлаас ангид боловсролтой, мэдлэгтэй монгол хүнийг бэлтгэхэд анхаарна.

4.1.19. Орчин үеийн технологи ашиглах ур чадвартай ажилчид бэлтгэж, бүтээмжид тохирсон цалин олгоно.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2024-2028

1.3.3.5. Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, 2 аймагт салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн баазыг байгуулна.

2.2.1.7. Хүүхдийн тооны өсөлт, ахлах сургуулийн төрөлжилт, сургалтын байгууллагыг цогцолбороор хөгжүүлэхтэй уялдуулан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийг өргөтгөж, шинээр барина. Сургууль, цэцэрлэгийн барилгын гамшиг, газар хөдлөлт, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартыг хангасан ижил загварын зурагтай болно.

2.2.1.10. Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангиас эхлэн англи хэл, кодчилал, роботик болон хиймэл оюуны ур чадварыг хөгжүүлэх сургалтыг нэвтрүүлнэ. Бүх түвшинд англи хэлний сургалтын чанарыг сайжруулж, ахлах сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагад зарим хичээлийг англи хэлээр заах боломжийг бүрдүүлнэ.

2.2.2.6. Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг ажил олгогчийн шаардлага болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, иргэдийг ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн, хосмог ажлын байрны сургалтыг нэвтрүүлнэ.

2.2.2.11. Суралцагчдад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрөөр суралцах, дараагийн түвшний сургалтад кредит шилжүүлэн сурах, зарим мэргэжлийн дээд боловсролын сургалтын байгууллагыг 3 жилд төгсөх боломжийг олгох зорилгоор мэргэжлийн эрхтэй ахлах сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, технологийн коллеж, их сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлнэ.

2.2.3.4. Багшлах хүний нөөцийг чадавхжуулж, цэцэрлэгийн 10000 багш, бага ангийн 2000 багш, ерөнхий боловсролын сургуулийн 11000 багш, англи хэлний 2000 багш, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2000 багшийг гадаад, дотоодод бэлтгэнэ.

Хуулиар хүлээсэн чиг үүрэг

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль

8.5. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг таван жил тутам магадлан итгэмжилнэ.

8.6. Боловсролын ерөнхий хуулийн 25.1.3-т заасан мэргэжлийн болон техникийн боловсролын эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.

8.7. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага Боловсролын ерөнхий хуулийн 35.7-д заасны дагуу дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чиг үүрэг

- 10.1.1.мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалт, мэргэжлийн сургалтыг зохион байгуулах;
- 10.1.2.элсэлт, төгсөлтийг Боловсролын ерөнхий хуулийн 26.1.22-т заасан журмын дагуу зохион байгуулах;
- 10.1.3.энэ хуулийн 9.12-т заасан байгууллагаар дамжуулан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, судалгаа хийх, зөвлөн туслах;
- 10.1.4.эзэмшсэн мэдлэг, ур чадварын үнэлгээг түншлэгч талтай хамтран зохион байгуулах;
- 10.1.5.өөрийн үйл ажиллагаанаас гадна Төсвийн тухай хуулийн 44.1-д заасан туслах үйл ажиллагаанаас орлого олох;
- 10.1.6.туслах үйл ажиллагааны үр дүнд бий болох өөрийн орлогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулах;
- 10.1.7.гадаад, дотоодын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагатай эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу хамтран ажиллах;
- 10.1.8.иргэнд боловсрол, мэргэжил эзэмших, мэргэшил болон ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 10.1.9.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байгаль орчинд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх;
- 10.1.10.түншлэлийг хэрэгжүүлэх;

Дэлгэрэнгүй мэдээлэл авах:

Бор-Өндөр суман дахь

Мэргэжлийн боловсролын сургууль

ДЧСМХ ажилтан: Г.Буянтогтох

103 тоот, Утас: 70567292